

Сангийн сайдын 2013 оны 05
дугаар сарын 31-ний өдрийн 125
дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

ҮНИЙН САНАЛ АВАХ ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

**(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА
ХУДАЛДАН АВАХАД АШИГЛАНА)**

2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт орсон.
**ХУУЛЬ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
БОДЛОГЫН ГАЗАР**

Улаанбаатар
2013 он

ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 50,000,000 төгрөгөөс доош төсөвт өртөгтэй бараа нийлүүлэх гүйцэтгэчийг харьцуулалтын аргаар сонгох болон шууд гэрээ байгуулах үед мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн барааг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах бараа буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч налуу үсгээр хаалтанд бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь, валют зэргийг бөглөнө. Үнийн санал ирүүлэгчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар

Утас: 267416, 267648

Web: www.e-procurement.mn

БАТЛАВ.

“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.ГҮРСОРОНЗОН

2021.08.05



“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ

**“ЛАБОРАТОРИЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛ”
ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН
БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт/
гэрээний нэр, дугаар:

“Лабораторийн багаж хэрэгсэл”
АТҮТ/202001008

Улаанбаатар хот
2021 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2021.08.05

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Лабораторийн багаж хэрэгсэл”-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **“2021.08.13-ны өдрийн 14 цаг 00 минут”**-аас өмнө **“tender.gov.mn”** цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **“2021.08.13”**-ны өдрийн **“14:30”** -т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **“Тооцно”**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ
Өөрийн байр, 111 тоот, утас 700-700-21

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- | | |
|--|--|
| 7. Санал
болгосон үнэ,
түүнийг үнэлэх | <p>7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p> <p>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.</p> <p>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p> |
| 8. Гэрээ
байгуулах эрх
олгох тухай
мэдэгдэл | <p>8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.</p> |

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1 ТӨӨЗ 3.1	Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд: 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 2. НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбар 3. Татварын өртэй эсэх тодорхойлолт /Эх хувь/ 4. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт 5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт 6. Харилцагч банкны тодорхойлолт /хугацаа хэтэрсэн зээлийн төлбөргүй байх/ 7. Санхүүгийн тайлан сүүлийн 2 жил /2019 он, 2020 он/ аудитын дүгнэлтийн хамт 8. 2019, 2020 оны борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь төсөвт өртгийн үнийн дүнгийн 70 хувиас багагүй төгрөг байна. 9. Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 оны аль нэг жилд ижил төстэй гүйцэтгэсэн ажлын мэдээлэл ирүүлнэ. /Гэрээ болон хүлээлцсэн актын хуулбарыг ирүүлнэ./ 10. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна. /Зээл нь судлагдаж банкны бичгээр баталгаажсан байна./ 11. Нийлүүлэх лабораторийн багаж хэрэгслийг техникийн тодорхойлолтод заасан шаардлага тус бүрээр харьцуулж ирүүлнэ. 12. Лабораторийн багаж хэрэгслийн баталгаат хугацаа 1 жилийг баталсан албан тоот ирүүлнэ. 13. Нийлүүлэх лабораторийн багаж хэрэгслийн үнийн хуваарийг баталгаажуулж ирүүлнэ. 14. Барааг 90 хоногийн дотор нийлүүлэх хуваарийг баталгаажуулж ирүүлнэ. 15. ТӨӨЗ: 4.2.1-4.2.9-д заасан шаардлагуудыг хангах мэдэгдлийг бичгээр баталгаажуулж ирүүлнэ. 16. Дээрх хавсралтаар ирүүлэх материалуудын огноо тендер зарлагдсанаас хойших он сар өдрөөр байна.
ТӨӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: “СБД, 2 дугаар хороо, Тээвэрчдийн гудамж, Автотээврийн үндэсний төвийн байр” Огноо: 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдөр Цаг: 14 цаг 00 минут хүртэл www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.
ТӨӨЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: СБД, 2 дугаар хороо, Тээвэрчдийн гудамж, Автотээврийн үндэсний төвийн байр Давхар болон өрөөний дугаар: 1-р давхар, Уулзалтын өрөө Огноо: 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдөр Цаг: 14 цаг 30 минут

ТОӨЗ 2.3	Тус жагсаалтын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. Мөн Сангийн сайдын 2019 оны 132 дугаар “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-ыг баримтална.
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: “Багцгүй”

Үнэлгээний хорооны дарга:

СХЧУТ-ийн ахлах мэргэжилтэн

А.Батчулуун

Нарийн бичгийн дарга:

ЗСХНХ-ийн мэргэжилтэн

Д.Пүрэвдагва

Гишүүд:

АҮХ-ийн дарга

Б.Мөнхжаргал

СХЧУТ-ийн чанарын менежер

Ч.Сайнбаяр

МТХ-ийн техник хангамжийн инженер

С.Түвшинжаргал

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** [Барааны тодорхойлолт, техникийн үзүүлэлтийг энд бичнэ.]
2. **Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл *[Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.]* гэж бичнэ
3. **Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
4. **Бараа хүргэх газар:** [Барааг хүлээж авах хаягийг бичнэ]
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8

**ХЭМЖИЛ ЗҮЙН ЛАБОРАТОРИЙН ЭТАЛОН ХЭМЖИХ ХЭРЭГСЭЛ,
ТОНОГ, ТӨХӨӨРӨМЖ, БАГАЖ ХЭРЭГСЛИЙН
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Ерөнхий шаардлага:

Эталон хэмжих хэрэгслүүд нь олон улсын нэгжийн СИ системийн дагуу тухайн улсын үндэсний эталон эсвэл итгэмжлэгдсэн лабораториос нэгж дамжуулагдсан шалгалт тохируулгын гэрчилгээтэй байна. Эталон хэмжих хэрэгсэл тус бүр нь ажиллуулах стандарт ажиллагааны зааварчилгаа, ашиглалтын гарын авлага, хөдөлмөр хамгааллын зааварчилгаа зэргийг техникийн баталгаат орчуулгаар Монгол хэл дээр орчуулагдсан байна.

Бүх багаж хэрэгслүүдийн баталгаат хугацаа 1 жил байх ба энэ хугацаанд гарах эвдрэл гэмтлийг нийлүүлэгч тал бүрэн хариуцна.

Металл бүтэцтэй хэмжих хэрэгслүүд нь зэврэлтээс хамгаалагдсан эсвэл түүнтэй дүйцэхүйц хамгаалах лак, будаг гэх мэт түрхлэгтэй байх ёстой. Цахилгаан тэжээлийн эх үүсвэр 220в, 380в байгаа тул тоног төхөөрөмжийн тэжээлийг тохируулах.

Бензин хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн утаан дахь хорт бодисыг хэмжих багаж нь СН нүүрс устөрөгч, СО нүүрстөрөгчийн исэл, СО₂ нүүрстөрөгчийн давхар исэл 3 төрлийн хийг хэмждэг. Санал болгож байгаа стандарт хий нь уг багажид тохиргоо, баталгаажуулалтыг хэмжлийн өндөр нарийвчлалтай хийх зориулалттайгаар бүтээгдсэн байна. Ерөнхий шаардлагад заагдсаны дагуу тухайн улсын үндэсний эталон эсвэл итгэмжлэгдсэн байгууллагын шалгалт тохируулгад хамрагдсан гэрчилгээтэй байна.

Стандарт хий нь нээж хаах хавхлагатай байхаас гадна, хийн даралтыг хэмжих хэрэгслээр тоноглогдсон байна.

Спидометр төхөөрөмж дээр тээврийн хэрэгслийг ажиллуулах үед аюулгүй байдлыг хангах үүднээс тээврийн хэрэгслийн ачаалж байгаа зүгээс эсрэг чигт бэхлэх бэхэлгээ нь шаланд бэхлэгдсэн байх ба 4-5метр зайнаас тээврийн хэрэгслийг хөдөлгөөнгүй байлгахаар зохион бүтээгдсэн байна. Бэхлэгч нь иж бүрдэл байх ба тээврийн хэрэгсэлд болон шаланд холбогдох холболтуудаар тоноглогдсон байна.

1. Техникийн шаардлага

№	Иж бүрдэл	Шаардлага	
1	Эргүүлэх хүчний тохируулгатай түлхүүр /1 ширхэг/	Хэмжих хязгаар	50n.m - 500n.m
		Дэлгэц	Дижитал, LCD
		Унших чадвар	0.1-0.01n.m
		Нарийвчлал	±2
		Урт	600-1000мм
		Тэжээл	AAA баттера
		Стандарт	ISO 6789-1:2017 Assembly tools for screws and nuts — Hand torque tools — Part 1: Requirements and methods for design conformance testing and quality conformance testing: minimum requirements for declaration of conformance
2	Дугуйн даралт хэмжигч манометр /дижитал/ /1 ширхэг/	Хэмжих хязгаар	0-16 бар, 0-220 psi
		Дэлгэц	Дижитал, LCD
		Хэмжээ	7.2 x 23см/2.8" x9"
		Жин	374гр-400гр
		Материал	Резинэн+Төмөр+Гуулин
3	Орчны даралт хэмжигч /2-ширхэг/	Хэмжилт	Орчны даралт
		Унших чадвар	≤1mbar
		Хэмжих хязгаар	350 -1100mbar,
		Нарийвчлал	±4mbar,
		Дэлгэц	Дижитал, LCD
		Тэжээл	Баттера AAA
		Жин	300-500гр
4	Цаг маягын индикатор /1-ширхэг/	Хэмжилт	Уртын хэмжил
		Унших чадвар	0.01-0.001мм
		Хэмжих хязгаар	0-30мм
		Нарийвчлал	±0.005мм
		Дэлгэц	Дижитал, LCD
		Тэжээл	Баттера 3в
5	Тээврийн хэрэгслээс ялгарах утаа гадагшлуулах систем /1-багц/	Цахилгаан тэжээл	220в/380в
		Өнгө	Метал, хар, цэнхэр
		Ажиллагаа	Автомат
		Хоолойн урт	8м дээш
		Жин	80кг
		Хоолойн диаметр	125мм-дээш
		Чадал	1.5квт
		Дамжуулах хоолойн урт	15м
		Дамжуулах хоолойн материал	Хөнгөн цагаан

6	Тээврийн хэрэгслийг спидометр төхөөрөмжид бэхлэх бэхэлгээ /1-багц/	Материал	Polyester
		Өргөн	150мм
		Урт	4м-5
		Ачаалал	15000кг-аас дээш
		Бэхэлгээ	Шал
7	4d лазер хэмжигч /1 ширхэг/	Хэмжилт	Өнцөг, гадаргуугын хэмжил
		Лазер өнгө	ногоон
		Хэмжих хязгаар	0-20м
		Нарийвчлал	±3мм/10м
		Дэлгэц	Дижитал, LCD
		Тэжээл	Баттєра 4000mAH (lithium)
		Лазерын төрөл	532Nm ≤
		Суурь	3 тулгууртай, 60см-150см сунадаг, өөрийнхөө тэгш байдлыг хангаж болохуйц бүтээгдсэн байна.
8	Стандартчилсан хий /2 ширхэг/	Хэмжилт	Бензин хөдөлгүүрээс ялгарах утааны найрлага хэмжигч багаж шалгах
		Найрлага	CO, CO2, CH
		Хэмжих хязгаар	CO (5.00-5.2) mol
			CO2 (14-14.9) mol
			CH (1980x10-6-2030 x10-6) mol
		Үйлдвэрлэгч	ISO 17034:2016-General requirements for the competence of reference material producer
		Багтаамж	8л-10л
		Даралт	9-10MPa
		Гэрчилгээ	ISO/IEC 17025:2017 General requirements for the competence of testing and calibration laboratories
9	Зөөврийн том оврын сэнс /1 ширхэг/	Зориулалт	Сорилт, туршилтын үед хөдөлгүүр хөргөх, эсрэг ачаалал өгөх
		Жин	50-60Kг
		Хэмжээ	120x60x160см
		Өнгө	Шар, хар
		Материал	Метал, пластик
		Тэжээл	380 в
		Чадал	20-30вт
		Тохиргоо	Сэнсний хүч тохируулах тохиргоотой байх

10	Тоног төхөөрөмж хэмжих хэрэгсэл зөөвөрлөх зөөврийн хайрцаг /нийт 6 ширхэг/	Зориулалт	Лабораторийн эталон, хэмжих хэрэгсэл явуулын нөхцөлд хадгалах, зөөвөрлөх хайрцаг
		Жин	5-20кг
		Материал	Метал, пластик, резин, хөөсөн
		Өнгө	Никель, цагаан
		Хэмжээ	39x25x20-1ширхэг
			30x25x35-1ширхэг
			30x45x85-1ширхэг
			20x20x85-3ширхэг
		Зураг	

Үнэлгээний хорооны дарга:

СХЧУТ-ийн ахлах мэргэжилтэн

А.Батчулуун

Нарийн бичгийн дарга:

ЗСХНХ-ийн мэргэжилтэн

Д.Пүрэвдагва

Гишүүд:

АҮХ-ийн дарга

Б.Мөнхжаргал

СХЧУТ-ийн чанарын менежер

Ч.Сайнбаяр

МТХ-ийн техник хангамжийн инженер

С.Түвшинжаргал

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.] |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ul style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]</p> |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн [moo]¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² | <p>9.1. Алданги оногдуулах хувь: [moo]</p> <p>Алдангийн нийт дүн: [moo]</p> |

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны ____ дугаар сарын ____ -наас _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]